2019 оны 48 дахь улирлын 6 дугаар

Дампуурсан тухай шийдвэрийг мэдээлэх нь

Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Дээд шүүх

Дампуурлын асуудлыг хэлэлцэх анхан шатны шүүх

2018 он. Дугаар 6083

Холбогдол бүхий иргэн: Ли Шаоминг

2019 оны 11 сарын 15-ны өдөр дээр дурдсан зээлдэгчтэй холбоотой дампуурсан талаарх шийдвэр гарсныг үүгээр мэдээлж байна. Улсад төлөх ёстой нийт өрийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид төлөх шаардлагатай.

2019,11,29

Филис Мак Кена

*Албан ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч*

---

Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Дээд шүүх

Компани татан буулгах асуудлын анхан шатны шүүх

2019 он дугаар 313

Компанийн /татан буулгах болон холбогдох бусад/ асуудлаарх

шийдвэр болон “Хятадын соёлын хот” ХХК-ийн тухай

Дээр дурдсан компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Дээд шүүх 2019 оны 10 сарын 10-ны өдөр хүлээн авсан ба уг нэхэмжлэлийг Хонконгт бүртгэлтэй, Централ дүүрэг, Конаут гудамж 30-32, Чуанс таувэр барилгын 15 давхарт байрлах “Шун Ву Юүэн” компаниас 2019 оны 12 сарын 19-ний өдрийн 09,30 цагт Шүүхэд сонсгох хүсэлтийн хамт гаргасан болно. Уг нэхэмжлэлд дурдсан асуудлыг дэмжих эсхүл эсэргүүцэх хүсэл бүхий дээр дурдсан компанийн зээлдүүлэгч болон оролцогч нар өөрсдөө биеэр эсхүл өмгөөлөгч, хуулийн зөвлөхөөрөө дамжуулан оролцох, мөн нэхэмжлэхийн хувийг тухайн компанийн зээлдүүлэгч болон оролцогч нарт холбогдох төлбөр хураамжийг төлсний үндсэн дээр гардуулан өгөх боломжтой.

2019,11,29

Ли&Партнэрс

Нэхэмжлэгчийн өмгөөлөгчид

Сентрал дүүрэг, Дэ Воу гудамж 19, Ворлдвайд хаус 22 давхар

Тэмдэглэх нь. Уг нэхэмжлэлийг хэлэлцэх  сонсголд оролцох хүсэлтэй иргэн нь дээр дурдсан өмгөөлөгч нарт шуудангаар болон биечлэн бичгээр илэрхийлсэн хүсэлтээ хүргүүлнэ. Уг хүсэлтэд компани бол байгууллагын, иргэн бол хувь хүний нэр, хаягийг тодорхой тусгаж гарын үсэг /өмгөөлөгчтэй бол өмгөөлөгчийн/-ээр баталгаажсан байх шаардлагатай ба 2019 оны 12 сарын 10-ны өдрийн 18,00 цагаас өмнө өмгөөлөгчдийн гарт хүргэгэдсэн байх ёстой.

Ноогдол ашгийн талаар мэдээлэх нь

Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Дээд шүүх

Дампуурлын асуудлыг хэлэлцэх анхан шатны шүүх

2012 он дугаар 6398

/Хэргийн хураангуй/

Холбогдол бүхий иргэн: Чан По Ки

Дээр дурдсан асуудлаар эхний бөгөөд эцсийн ноогдол ашиг болох 21,368%-ийг нэхэмжилсэн бөгөөд үүнийг 2019 оны 11 сарын 29-нөөс хойш төлөх шаардлагатай.

2019,11,29

Филис Мак Кена

*Албан ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч*